

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Я.АМАРЖАРГАЛ

НИЙЛҮҮЛЭГЧ

"АЗИФАРМА" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.ЭНХСАЙХАН

ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД
БОЛОН ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ҮЕД ШААРДЛАГАТАЙ ЭМ ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ, ЖИЖИГ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Азифарма" ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 11 дүгээр сарын-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь Шинэ төрлийн коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед шаардлагатай Багц 8 "Эноксапарины натри 40мг-0,4мл найрлага бүхий тариур" худалдан авах гэрээг 58,410,000 (тавин найман сая дөрвөн зуун арван мянган) төгрөг, Багц 16 "Осельтамивир 30мг капсул, Осельтамивир 6мг/мл-50мл, 65мл, 75мл ууж хэрэглэх хөвмөл бэлтгэх нунтаг" худалдан авах гэрээг 164,800,000 (нэг зуун жаран дөрвөн сая найман зуун мянган) төгрөг, Багц 19 "Ацетаминофен 125мг, 250мг шулуун гэдсээр хэрэглэх лаа, 500мг шахмал" худалдан авах гэрээг 224,640,000 (хоёр зуун хорин дөрвөн сая зургаан зуун дөчин мянган) төгрөгөөр (цаашид "бараа" гэх) нийт 447,850,000 (дөрвөн зуун дөчин долоон сая найман зуун тавин мянга) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцын дугаар	Үйлдвэрлэгч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
1	Эноксапарины натри	№8	Yoo Young, Солонгос	бүхий тариур	4,500	12,980	58,410,000
2	Осельтамивир 30мг	№16	Юхан, Солонгос	ширхэг	70,000	1,300	91,000,000

3	Осельтамивир 6мг/мл-65мл	№16	Юхан, Солонгос	ширхэг	3,000	24,600	73,800,000
4	Ацетаминофен	№19	Денк, Герман	ширхэг	144,000	460	66,240,000
5	Ацетаминофен	№19	Денк, Герман	ширхэг	288,000	510	146,880,000
6	Ацетаминофен	№19	Тавин-Ус, Монгол	ширхэг	288,000	40	11,520,000
Нийт дүн							447,850,000

- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 447,850,000 (дөрвөн зуун дөчин долоон сая найман зуун тавин мянган) төгрөгийг Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь 6 нэр төрлийн барааг 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцын дугаар	Урьдчилгаа /төгрөг/ 50%	Гүйцэтгэл /төгрөг/ 50%
1	Эноксапарины натри	№8	29,205,000	29,205,000

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлттөд.

2	Осельтамивир 30мг	№16	45,500,000	45,500,000
3	Осельтамивир 6мг/мл-65мл	№16	36,900,000	36,900,000
4	Ацетаминофен	№19	33,120,000	33,120,000
5	Ацетаминофен	№19	73,440,000	73,440,000
6	Ацетаминофен	№19	5,760,000	5,760,000
Нийт дүн			223,925,000	223,925,000

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
- (б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
- (в) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (г) “Хүчинтэй болох хугацаа” Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.
- (д) “Ашиглагч” Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.
- (е) “ГЕН” Гэрээний Ерөнхий Нөхцөл.
- (ж) “Бараа” Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм,эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.
- (з) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
- (и) “Бүртгэлийн гэрчилгээ” хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.
- (к) “ГТН” Гэрээний Тусгай Нөхцөл.
- (л) “Үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн хариуцах үйлчилгээг хэлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Тодорхойлолт (ГЕН-ийн Зүйл 1)

ГЕН 1.1 (и)	Захиалагч нь Эрүүл мэндийн яам
ГЕН 1.1 (о)	Нийлүүлэгч нь: "Азифарма"ХХК
ГЕН 1.1 (н)	Байршил: УБ хот, БГД, 2-р хороо, Гранд плаза 1105 тоот
ГЕН 1.1 (е)	Ашиглагч байгууллага: Эрүүл мэндийн яам

2. Үйлчлэх хүрээ (ГЕН-ийн Зүйл 2)

ГЕН 2	"ГЕН-ийн 2-т хамаарах тусгай нөхцөл байхгүй"
-------	--

3. Барааны гарал үүслийн улс (ГЕН-ийн Зүйл 3)

ГЕН 3	"ГЕН-ийн 3-т хамаарах тусгай нөхцөл байхгүй" гэж бичих
-------	--

4. Стандарт (ГЕН-ийн Зүйл 4)

ГЕН 4	"ГЕН-ийн 4-т хамаарах тусгай нөхцөл байхгүй"
-------	--

5. Гэрээний баримт бичгийг хэрэглэх (ГЕН-ийн Зүйл 5)

ГЕН 5	ГЕН-ийн 5-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

6. Барааны бүртгэлийн гэрчилгээ (ГЕН-ийн Зүйл 6)

ГЕН 6.1	Монгол улсад бүртгэгдсэнийг нотлох холбогдох бүртгэлийн болон болон бусад гэрчилгээний талаар оруулах
---------	---

7. Оюуны өмчийн эрх (ГЕН-ийн Зүйл 7)

ГЕН 7	ГЕН-ийн 7-д хамаарах тусгай нөхцөл байхгүй
-------	--

8. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН-ийн Зүйл 8)

ГЕН 8.1	Гэрээний үнийн дүнгийн 5% -аар гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.
ГЕН 8.4	Техникийн тодорхойлолтоос зөрүүтэй бүтээгдэхүүн нийлүүлсэн тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг хүчингүй болгоно.

9. Шалгах болон турших (ГЕН-ийн Зүйл 9)

ГЕН 9.1	Нийлүүлэлт хийхэд барааг техникийн тодорхойлолтод нийцэж буй эсэхийг шалгана.
---------	---

10. Баглаа боодол (ГЕН-ийн Зүйл 10)

ГЕН 10.2	бүтээгдэхүүний чанарыг алдагдуулахаас сэргийлсэн үйлдвэрлэгчээс тодорхойлсон хадгалалт, тээвэрлэлтийн нөхцлийг хангасан байна.
----------	--

11. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт

ГЕН 11.1	(CIP нөхцөл) Монгол улсын гаднаас нийлүүлэх барааны хувьд: Нийлүүлэгч барааг тээврийн хэрэгсэлд ачсан даруй энэ тухай бүрэн мэдээллийг захиалагч болон даатгалын байгууллагад бичгээр мэдэгдэнэ.
----------	---

26. Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)

ГЕН 26 ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй

27. Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)





ГЕН 27.1 Монгол хэл

28. Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)

ГЕН 28.1 Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө

29. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)ГЕН 29.1 Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр,
Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2**30. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)**

ГЕН 30 Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга  Н.Гэрэлт-ОдЭдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга  Д.НарантуяаЭрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга  Г.ЦэцэнсанааЭрүүл мэндийн яамны Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга  Т.ХонгорзулЭрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн мэргэжилтэн  Д.МөнхцэцэгЭрүүл мэндийн яамны яарав  П.Энхболор

14210 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII бай

Утас:263695

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Азифарма" ХХК-ны Тендерийн албаны дарга

 3.ЦэрэнхүүХаяг: Улаанбаатар хот, БГД, 2-хороо, Гранд плаза 1105тоот
Утас: 94107848, 88014487

Харилцах банк: Хаан банк

Дансны дугаар: 5021019647

95591213